


Шүгэл үлээх системийн

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2026 оны 02 сар



АГУУЛГА

- ШҮГЭЛ ҮЛЭЭХ СИСТЕМ
- ЁС ЗҮЙН СУРГАЛТ



"Говь" ХК 2022 онд байгууллагын үйл ажиллагааны ёс зүйн доголдлыг эрт үед нь илрүүлэх гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, засаж сайжруулах, ажилтны байгууллагадаа итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор “Шүгэл үлээх удирдлагын тогтолцоо”-г нэвтрүүлж, шүгэл үлээх систем болон бусад эх сурвалжийг ашиглалтад оруулсан ба системийн үйл ажиллагааг жил бүр сайжруулан, хэрэгжүүлсээр байна.

Шүгэл үлээх
боломжтой эх
сурвалжууд



<https://info.gobi.mn/whistleblowing>



70139977-6



Бусад / Ярилцлага, бичгээр/

Дээрх эх сурвалжаар ирсэн мэдээллийн төрөл, зэрэглэл, хамрах хүрээ зэргээс шалтгаалан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, Нэр дэвшүүлэх хороо, Ёс зүйн хороо шууд хүлээн авч аливаа ёс зүйн зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх, сайжруулах, шударга тогтолцоог ханган ажиллахаар зохицуулагдсан.

2025 онд “Шүгэл үлээх систем”-д нийт 71 шүглийн мэдээлэл ирсэн байна



Системээр

68%



Бусад сувгаар


20%



Утсаар


13%

Зөрчил, мэдээлэл шийдвэрлэсэн байдал





Шүгэл үлээгч болон мэдээллийн нууцлалыг хадгалах суурь зарчмыг алдагдуулахгүйгээр, нэг удаагийн олгогдсон дугаар ашиглан шүгэл үлээгч мэдээлэл хүлээн авагчтай чат хэлбэрээр харилцах, нэмэлт мэдээлэл хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр шүгэл үлээгч болон мэдээлэл хүлээн авагчийн хоорондын эргэх холбоо сайжирч, мэдээлэл солилцооны үр нөлөө нэмэгдсэн.



Шүгэл үлээх системээр ирсэн мэдээллийн төрөл, тоо (2025)

Харилцааны зөрчил	Эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой зөрчил
20	2
Ажлын байрны дарамт, хавчлага	Өөртөө болон бусдад давуу байдал олгох зөрчил
14	2
Санал хүсэлт	Мөнгө, бараа материал, бусад хөрөнгийн зүй бус ашиглалттай холбоотой зөрчил
12	1
Хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөрчил	Ялгаварлан гадуурхахтай холбоотой зөрчил
8	1
Дотоод дүрэм, журам зөрчсөнтэй холбоотой зөрчил	Бусад
2	1
Ёс зүйн кодтой холбоотой зөрчил	Шаардлага хангахгүй
2	6



Мэдээллийн эх сурвалж, зөрчлийн төрөл, шийдвэрлэсэн байдлаар ангилбал:

Эх сурвалж	Зөрчлийн төрөл	Тоо	Шийдвэрлэсэн байдал
Шүгэл үлээх сувгаар 48; Утсаар-9; Бусад сувгаар-14	Харилцааны зөрчил	20	15-Холбогдох газар, нэгж болон ажилтанд зөвлөмж, мэдээлэл хүргүүлэв. 5-Холбогдох газар, нэгжид мэдээлэл шилжүүлж шийдвэрлэв.
	Ажлын байрны дарамт, хавчлагатай холбоотой зөрчил	14	12-Холбогдох газар нэгжид зөвлөмж, үүрэг даалгавар хүргүүлж шийдвэрлэв.
			1-Өмнө нь шийдвэрлэсэн мэдээлэл байсан тул буцааж шийдвэрлэв.
			1-Холбогдох газар, нэгжид мэдээлэл шилжүүлж шийдвэрлэв.
	Санал хүсэлт	12	10-Холбогдох газар, нэгжтэй хамтран шийдвэрлэв.
			2-Шүгэл үлээгчийн хүсэлтээр мэдээллийг буцааж шийдвэрлэв.
	Хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөрчил	8	4-Холбогдох газар, нэгж болон ажилтанд зөвлөмж, тогтоол хүргүүлэв.
			2-Холбогдох газар, нэгжид мэдээлэл шилжүүлж шийдвэрлэв.
			2-Ирүүлсэн мэдээлэлд зөрчил, үл тохирол илрээгүй болон Ёс зүйн хорооны харъяалан шийдвэрлэх асуудал биш тул буцааж шийдвэрлэв.
	Ёс зүйн кодтой холбоотой зөрчил	2	1-Холбогдох дүгнэлтийг гаргаж шийдвэрлэв.
			1-Холбогдох газар, нэгжид мэдээлэл шилжүүлж шийдвэрлэв.
	Эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой зөрчил	2	2-Холбогдох газар, нэгжтэй хамтран шийдвэрлэв.
	Дотоод дүрэм, журам зөрчсөн зөрчил	2	Холбогдох газар, нэгжтэй хамтран шийдвэрлэв.
	Өөртөө болон бусдад давуу байдал олгох зөрчил	2	1-Холбогдох ажилтан ажлаас гарсан тул хааж шийдвэрлэв.
			1-Холбогдох газар, нэгжид мэдээлэл шилжүүлж шийдвэрлэв.
	Мөнгө санхүү, бараа материал болон бусад хөрөнгийн зүй бус ашиглалттай холбоотой зөрчил	1	Холбогдох газар, нэгжид үүрэг даалгавар хүргэж шийдвэрлэв.
	Ялгаварлан гадуурхахтай холбоотой зөрчил	1	Холбогдох газарт зөвлөмж хүргүүлж шийдвэрлэв.
	Бусад	1	Холбогдох газар, нэгжтэй хамтран шийдвэрлэв.
	Шаардлага хангахгүй	6	Мэдээлэл хүлээн авах шаардлага хангаагүй тул буцааж шийдвэрлэв.
Нийт		71	



"Шүгэл үлээх суваг"-аар ирсэн мэдээллийг эх сурвалж болон зөрчлийн төрөл, хариуцах нэгжээр ангилбал:

Эх сурвалж	Зөрчлийн төрөл	Хариуцах газар			Нийт
		Нэр дэвшүүлэх хороо	Ёс зүйн хороо	Комплайнсын газар	
Шүгэл үлээх сувгаар 48; Утсаар-9; Бусад сувгаар-14	Харилцааны зөрчил	2	15	3	20
	Ажлын байрны дарамт, хавчлагатай холбоотой зөрчил	5	2	7	14
	Санал хүсэлт	2	3	7	12
	Хөдөлмөрийн харилцааны зөрчил	1	4	3	8
	Ёс зүйн кодтой холбоотой зөрчил	1	1		2
	Эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой зөрчил			2	2
	Дотоод дүрэм, журам зөрчсөн зөрчил			2	2
	Өөртөө болон бусдад давуу байдал олгох зөрчил	2			2
	Мөнгө санхүү, бараа материал болон бусад хөрөнгийн зүй бус ашиглалттай холбоотой зөрчил	1			1
	Ялгаварлан гадуурхахтай холбоотой зөрчил		1		1
	Бусад		1		1
	Шаардлага хангахгүй	1	2	3	6
Нийт		15	29	27	71



Ирсэн мэдээллийн төрөл, зэрэглэл, хамрах хүрээ зэргээс шалтгаалан журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Ёс зүйн хороо, Комплайнсын газар хүлээн авч шийдвэрлэдэг.

Шийдвэрлэсэн байдал		Тоо
Нэр дэвшүүлэх хорооны	Тогтоол, санал зөвлөмж	4
	Шийдвэр, үүрэг даалгавар	2
Ёс зүйн хорооны	Зөвлөмж	20
	Шийдвэр	2
	Дүгнэлт	1
Комплайнсын газрын	Зөвлөмж	4
Нийт		33



Ажлын байран дах ёс зүйтэй харилцааны ач холбогдол, зөрчил мэдээлэх соёлын талаарх ойлголтыг нэмэгдүүлж ажлын байрны зөв дадлыг бэхжүүлэх зорилго бүхий **"Ажлын байрны ёс зүй ба Шүгэл үлээх зөв соёл"** сэдэвт сургалтыг 947 хүн цаг буюу нийт ажилтны 65% -ийг хамруулан оров.

“Корпорейт Комплаенс Менежмент” ХХК- аас авсан зөвлөх үйлчилгээний хүрээнд **“Ажлын байрны ёс зүй”** сургалт авав.



Хамрах хүрээ:
Албаны дарга болон ахлах
ажилтнууд
Сургалтад хамрагдсан
ажилтны тоо: **34**



GOBI

Анхаарал хандуулсанд баярлалаа.